



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.4, 63.1.18 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бэлэн мөнгө эсхүл компанийн хувьцаа болон бусад этгээдийн үнэт цаас хэлбэрээр хуваарилсан ногдол ашгийг зөвхөн эрх бүхий зуучлагч байгууллага болох “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулан ногдол ашиг хуваарилах гэрээний үндсэн дээр тарааж байхыг нээлттэй хувьцаат компаниудын удирдлагуудад үүрэг болгосугай.

2. Давуу эрхийн хувьцаа болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь арилжааны банк дахь өөрийн харилцах болон хадгаламжийн дансанд ногдол ашгийг шилжүүлж авахаар бичгээр хүсэлт гаргаж, холбогдох мэдээллийг өгсөн тохиолдолд ногдол ашгийг нээлттэй хувьцаат компани хувьцаа эзэмшигчийн дансанд байршуулах боломжтойг тэмдэглэсүгэй.

3. “ҮЦТХТ” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны хадгаламжийн журам”-ын дагуу ногдол ашгийг зуучлуулан тараалгахад хадгалуулагчаас авч буй үйлчилгээний хөлс болох 100 /нэг зуу/ төгрөгийн шимтгэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг “ҮЦТХТ” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл /Л.Сонор/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дараах чиг үүрэг бүхий байгууллагуудаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийн мэдээллийг тогтмол хүргэж ажиллахад анхаарч ажилласугай.

1/ “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулан ногдол ашиг тараалгах гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигчид болон брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдэд хүргэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тухай бүр тус Хороонд мэдэгдэж байхыг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа /-д;

2/ “ҮЦТХТ” ХХК-аас брокер, дилерийн компаниудад ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээлэл ирсэн даруйд холбогдох хувьцаа эзэмшигчдэд ажлын 5 хоногт багтаан мэдээллийн сувгуудыг ашиглан түгээхийг брокерын үйл ажиллагаа эрхэлж буй компаниудад тус тус үүрэг болгосугай.


5. Хэрэв хувьцаа эзэмшигч нь үнэт цаасны дансгүй бол түүнд хуваарилсан ногдол ашгийг хувьцааны данс нээгдсэн тухай бүр дансанд нь байршуулахыг “ҮЦТХТ” ХХК-д зөвшөөрсүгэй.

6. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

7. Энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасан холбогдох арга хэмжээ авахыг нээлттэй хувьцаат компаниуд, “ҮЦТХТ” ХХК, брокерийн компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлагад анхааруулсугай.

8. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН